



ТАМХИНЫ ХУДАЛДАА ЭРХЛЭГЧДЭД

САНАМЖ

Тамхины худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээд дараах шаардлагыг хангаж ажиллана:

1.Тусгай зөвшөөрөл авсан иргэн, хуулийн этгээд мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн эрүүл мэндийн дүгнэлттэй тамхийг худалдах

2. Худалдааны бөөний төв нь тамхийг худалдан авагчдад нийлүүлэхдээ мэргэжлийн хяналтын байгууллагаас олгосон эрүүл мэндийн дүгнэлтийг дагалдуулсан байх

3.Тамхийг худалдааны байгууллагын кассын дэргэд байрлуулахгүйгээр тусгайлсан лангуугаар худалдаалах

4.Шаардлагатай тохиолдолд худалдан авагчийн насыг тодорхойлох зорилгоор иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримтаа үзүүлэхийг шаардах, бичиг баримт үзүүлэхээс татгалзсан тохиолдолд тамхи, тамхи нь бүтээгдэхүүн худалдаахгүй байх

5.Орох хаалга, хүлээлгийн танхим, хонгил, бие засах газар болон бусад шаардлагатай газар тамхи татахыг хориглосон анхааруулах тэмдэг байрлуулсан эсэхэд хяналт тавих

6.Тамхины хяналтын тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Тамхины худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээд дараах худалдаа, үйлчилгээ явуулахыг хориглоно:

1.Баяр ёслол, биеийн тамирын уралдаан тэмцээн, соёл урлагийн арга хэмжээ, спорт, аялал зугаалга, өдөрлөг зэрэг олон нийтийг хамран зохион байгуулагдаж байгаа газар тамхи худалдаалах

2.Зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт тамхины худалдаа үйлчилгээ эрхлэх

3.Тамхийг ширхэгээр, гудамж талбайд, гар дээрээс болон дуудлагаар хүргэх үйлчилгээгээр худалдах

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Ерөө сумын Засаг даргын
2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн
А/185 дугаар захирамжийн хавсралт



ТАМХИ ХУДАЛДААЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХОД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

№	Баримт бичгийн нэр	Анхаарах зүйл	Тайлбар
1	Албан бичиг / Өргөдөл	Эх хувь	Аж ахуйн нэгж бол албан хүсэлт, иргэн бол өргөдөл "Үйлчилгээний газрын оноосон нэр, үйл ажиллагааны чиглэл, хаяг байршил, холбогдох утасны дугаар зэргийг тодорхой бичнэ."
2	Гэрчилгээ/Иргэний үнэмлэх/	Хуулбар	Аж ахуйн нэгж бол улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэн бол иргэний үнэмлэх
3	Ажлын байрны дүгнэлт	Хуулбар	Мэргэжлийн хяналтын хэлтсээс Ажлын байрны дүгнэлт эсвэл Худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн мэдээллийн санд бүртгэгдсэн бүртгэлийн хуудас
4	Багийн Засаг даргын тодорхойлолт	Эх хувь	Аж ахуйн нэгж байгууллага нь Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байр болон дотуур байрнаас 500м зайд оршдог тухай Харъяа багийн Засаг даргын тодорхойлолт
5	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хамтран ажиллах түншлэлийн гэрээ	Хуулбар	Цагдаагийн хэлтэс, багийн засаг даргатай байгуулсан гэрээ
6	Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хураах, тээвэрлэх гэрээ	Хуулбар	Татварын хэлтэс, хог хаягдал тээвэрлэлтийн компанитай хийсэн гэрээ
7	Ажлын байрны эзэмшлийн баталгаа	Хуулбар	Газар болон үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, түрээслэдэг бол түрээсийн гэрээ
8	Төлбөр төлсөн баримт	Эх хувь	ЗДТГ-ын Төрийн сан 100130200955 тоот дансанд төгрөгийн хурамжийг төлнө.
9	Зураг	Эх хувь	Барилга байгууламжийн гадна болон дотор талын фото зураг Гадна талбай барилга бүтнээр орсон байх